



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 28 нэрийн, нийт 21,280,520.94 (хорин нэгэн сая хоёр зуун наян мянга таван зуун хорин төгрөг ерэн дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга С.Цэдэнбалжир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны... дугаар сарын...-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг бүрийн балансын үнэ /төгрөг/	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Компьютер-3	2008-12-31	1	468,000.00	468,000.00
2	Принтер-1	2011-04-24	1	125,499.00	125,499.00
3	Олшруулагч	1998-01-01	1	1,266,300.00	1,266,300.00
4	Компьютер-2	2008-12-31	3	775,108.51	2,325,325.53
5	Компьютер TFT-170	2014-11-28	1	1,437,843.00	1,437,843.00
6	Валена /хятад/	2015-09-01	1	600,000.00	600,000.00
7	Валена /герман /	2015-09-01	1	850,000.00	850,000.00
8	Азотын сав	2015-09-01	1	1,200,000.00	1,200,000.00
9	Компьютер- ариунаа	2007-12-31	1	653,235.00	653,235.00
10	Компьютер DELL OP 720	2012-07-25	1	1,210,000.00	1,210,000.00
11	Зөөврийн компьютер	2013-12-31	1	1,099,000.00	1,099,000.00
12	Принтер Laser dell 1130	2012-07-25	1	176,000.00	176,000.00
13	Зөөврийн компьютер	2011-11-30	1	1,296,800.00	1,296,800.00
14	Хувь машин цаас тавигч	2013-09-24	1	888,097.50	888,097.50
15	Компьютер-нярав	2013-06-10	1	450,000.00	450,000.00
16	Зөөврийн Аудио систем/иж бүрэн/	2011-11-30	1	1,080,900.00	1,080,900.00
17	Мотофомп	1974-11-01	2	189,945.00	379,890.00
18	Ачигч	1977-09-01	1	234,989.00	234,989.00
19	Хувилагч машин	2013-09-24	1	1,769,346.41	1,769,346.41
20	Ямаха мотор	2001-02-01	1	434,160.00	434,160.00
21	Тог баригч 2017.12.12	2017-12-12	4	125,290.00	501,160.00
22	Принтер SCX-4300	2011-04-25	1	350,000.00	350,000.00
23	Мебель ширээ	2005-01-01	3	372,250.00	1,116,750.00
24	Модон сандал	2003-01-01	5	13,567.50	67,837.50
25	Албан хаагчдын ширээ	2008-12-31	7	122,900.00	860,300.00
26	Хивс-	1986-09-01	1	104,198.00	104,198.00
27	Хивс-	2010-12-20	1	320,000.00	320,000.00
28	Ханын шүүгээ	2005-01-01	1	14,890.00	14,890.00
НИЙТ ДҮН			46		21,280,520.94 (хорин нэгэн сая хоёр зуун наян мянга таван зуун хорин төгрөг ерэн дөрвөн мөнгө)